



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

АЗАНэгтгэл ТӨХК-ний Сүхбаатар аймаг дахь салбарын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СБА-2026/003/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт хот  
2026 он

Дарга,  
тэргүүлэх аудитор: Г.Даваа  
Утас: 70518396  
Аудитын менежер: М.Нарантуяа  
Утас: 70512123  
Ахлах аудитор: С.Ариунбаяр  
Утас: 70512123

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	7
3.1 Зөвлөмж:.....	7
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	8

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,  
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,  
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075  
Утас: (976) 70518396  
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2026.03.15 № 203

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу АЗЗА нэгтгэл ТӨХК-ний Сүхбаатар салбарын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

АЗЗА нэгтгэл ТӨХК-ний Сүхбаатар салбарын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлого үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон холбогдох хууль тогтоомжид заасан орлогын дутагдлыг нөхөх зорилгоор иргэн, хуулийн этгээдээс авсан богино хугацаат зээлийг гэрээний хугацаанд төлж барагдуулаагүй бөгөөд санхүүгийн тайланд 393,905.0 мянган төгрөгийн өглөг бүртгэгдсэн байна. Уг дүн нь тайлант үеийн нийт өр төлбөрийн 25.5 хувийг эзэлж байгаа нь байгууллагын өр төлбөрийн бүтэц, төлбөрийн чадварт нөлөөлөхүйц ач холбогдолтой тул хэрэглэгчдийн анхаарлыг хандуулах зорилгоор энэхүү асуудлыг онцлон дурдав.

### Аудитын гол асуудал

Санхүүгийн тайланд 249,000.0 мянган төгрөгийн авлага бүртгэгдсэн бөгөөд уг авлагатай холбоотой ажил гүйлгээ нь харилцагч байгууллагатай маргаантай

нөхцөл үүссэн, авлагыг барагдуулах эсэх тодорхойгүй байдалтай байна. Авлагын нөхөн төлөгдөх боломж, бүртгэлийн үнэлгээ нь санхүүгийн тайлангийн хөрөнгийн бодит байдлыг тодорхойлоход чухал нөлөөтэй бөгөөд аудитын явцад нэмэлт сорил, баримт нотолгоо шаардагдсан тул энэхүү асуудлыг аудитын гол аудитын асуудалд хамруулан авч үзэв.

### **Бусад асуудал**

Аудиторын дүгнэлтэд өөрчлөлт оруулахгүйгээр мэдээлэхэд, тус аудитын хүрээнд санхүүгийн тайланд хавсаргасан үйл ажиллагааны тайлан, статистик мэдээлэлд аудитын баталгаа өгөөгүй бөгөөд эдгээр нь аудитын дүгнэлтийн хамрах хүрээнд хамаарахгүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10,173,287.26	20,198,286.77
1.1.2	Дансны авлага	274,430,520.33	10,590,649.23
1.1.6	Бараа материал	469,147,937.17	506,579,385.19
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	312,705,431.12	561,709,124.12
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,066,457,175.88	1,099,077,445.31
1.2.1	Үндсэн хөрөнгө	838,286,171.70	737,875,033.56
1.2.2	Биет бус хөрөнгө	227,081,111.16	226,081,111.20
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,065,367,282.86	963,956,144.76
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,131,824,458.74	2,063,033,590.07
2.1.1.1	Дансны өглөг	737,929,963.24	1,150,023,615.16
2.1.1.2	Цалингийн өглөг	-	36,973,368.00
2.1.1.3	Татварын өр	194,966,126.66	298,018,426.78
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	60,238,917.83
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	932,896,089.90	1,545,254,327.77
2.2	Өр төлбөрийн нийт дүн	932,896,089.90	1,545,254,327.77
2.3.1	Өмч: -төрийн	1,419,824,140.26	1,419,824,140.26
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	338,036,729.71	338,036,729.71
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(558,932,501.13)	(1,240,081,607.67)
4602	Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг, алдагдал	(558,932,501.13)	(606,856,937.77)
4601	Тайлант үеийн ашиг, алдагдал	-	(633,224,669.90)
2.3.10	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,198,928,368.84	517,779,262.30
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	2,131,824,458.74	2,063,033,590.07

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,198,996,552.36	1,370,677,972.52
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	1,700,263,376.42	1,274,357,473.97
3	Нийт ашиг ( алдагдал)	498,733,175.94	96,320,498.55
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	62,182.62
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	738,051,496.60	447,610,779.31
11	Санхүүгийн зардал	98,075,733.00	178,856,678.26
12	Бусад зардал	-	103,139,893.50
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-

18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(337,394,053.65)	(633,224,669.90)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(337,394,053.65)	(633,224,669.90)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(337,394,053.65)	(633,224,669.90)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Орлогын нийт дүн	(337,394,053.65)	(633,224,669.90)

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Балансын үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Нийт дүн
2024 ОНЫ 12-Р САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	1,419,824,140.26	338,036,729.7	(558,932,501.13)	1,198,928,368.84
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(47,924,436.64)	(47,924,436.64)
Залруулсан үлдэгдэл	1,419,824,140.26	338,036,729.7	(606,856,937.77)	1,151,003,932.20
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	(633,224,669.90)	(633,224,669.90)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарлагдсан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-
2025 ОНЫ 12 САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	1,419,824,140.26	338,036,729.7	(1,240,081,607.6)	517,779,262.30

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,052,018,798.00	868,657,241.51
1.1.1	Бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого	17,023,468.00	798,990,269.89
1.1.5	Татаас санхүүжилтийн орлого	1,582,470,230.00	-
1.1.5	Татаас санхүүжилтийн орлого	1,582,470,230.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	452,525,100.00	69,666,971.62
1.2	Мөнгөн зарлага	2,291,774,273.56	808,632,242.00
1.2.1	Ажилчдад төлсөн	455,978,513.70	503,819,484.50
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	131,669,411.52	101,947,219.91
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	291,849,952.55	500,450.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	291,849,952.55	-
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	9,993,729.55	10,206,016.65
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	538,850,520.97	20,087,797.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	97,790,033.00	27,230,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	97,790,033.00	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	88,540,235.99	10,091,619.68
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	52,500.00	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	677,049,376.28	134,749,654.26
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(239,755,475.56)	60,024,999.51
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	(50,000,000.00)
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	(50,000,000.00)

3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	705,000,000.00	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,199,900.00	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,899,900.00	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,300,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(7,199,900.00)	(50,000,000.00)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	705,000,000.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	450,000,000.00	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	450,000,000.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	255,000,000.00	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	8,044,624.44	10,024,999.51
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,128,662.82	10,173,287.26
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,173,287.26	20,198,286.77

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн үндсэн хөрөнгө, авлагын данстай холбоотой зөрчилд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн зөвлөмж өгсөн. Үүнд:

#### 3.1 Зөвлөмж:

##### 3.1.1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Дансанд бүртгэлтэй лабораторийн тоног төхөөрөмж, аж ахуйн материалыг биечлэн, нэр төрлөөр ангилан тоолж баталгаажуулаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар 12.1<sup>1</sup>, 12.2<sup>2</sup>, 20 дугаар зүйлийн 20.2.6<sup>3</sup>, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72<sup>4</sup>, 73<sup>5</sup> дугаар зүйл, толилуулга, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй лабораторийн тоног төхөөрөмжийг нэр, төрөл, тоо ширхгээр биечлэн тоолж, албан тушаалтанд хариуцуулж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах;

##### 3.1.2. Авлагын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Гэрээгээр гүйцэтгэсэн ажил үйлчилгээний төлбөрийг тооцоо нийлээгүй, ажлын гүйцэтгэл маргаантай байхад авлагаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5<sup>6</sup>, заалт, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэл хангаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Гэрээгээр гүйцэтгэсэн ажил үйлчилгээний төлбөрийг тооцоо нийлээгүй, ажлын гүйцэтгэл маргаантай авлагыг (Алаг тогоо ХХК, Талын гал ХХК) хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.

<sup>2</sup> Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:

<sup>3</sup> эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

<sup>4</sup> Тооллогын комисс, түүний эрх, үүрэг

<sup>5</sup> Эд хөрөнгийн тооллого явуулах журам

<sup>6</sup> дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тооллого дутуу хийсэн	1	-					1	-				
Тооцоо нийлээгүй авлага бүртгэсэн	1	-					1	-				
	2						2			-	-	-